

жилтийн үйл явцыг улам бүр бэрхшээл, зөрчилтэй, нарийн төвөгтэй болгож байна.

АЖ АХУЙН ШИНЭТГЭЛ, НЭЭЛТТЭЙ БОДЛОГЫН ХУУЛЬ ЭРХИЙН АСУУДАЛ

Д. Шүрхүү

1978 оны III бүгд хурлаас хойш ХКН хүч анхаарлаа «дөрвөн шинэчлэлт»-ийг хэрэгжүүлэхэд төвлөрүүлж, аж ахуйг удирдах систем, эрхлэх арга барилд эрс шинэтгэл хийж, гадаад эдийн засгийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх шийдвэр гаргасан билээ. Энэхүү чиг шугамыг 1982 онд хуралдсан ХКН-ын XI их хурлын шийдвэр, мөн онд баталсан шинэ Үндсэн хуулинд тодорхой тусгаж хуульчлан баталсан нь эрхзүйн үзэл суртлын гол чиглэл, БНХАУ-ын хууль тогтоомжийн тулгуур үндэс болсон юм.

Сүүлийн таван жилд гаргасан 50 орчим хууль тогтоомжийн тэн хагасыг аж ахуйн холбогдолтой хууль дүрэм эзэлж байгаа боловч өнөөгийн эрэлт шаардлагаас хол хоцорч байна¹. Ойрын хугацаанд 80 гаруй хуулийг бэлтгэн гаргахаар төлөвлөж байгаагийн дотор төсөв, банкы үйл ажиллагаа, төмөр зам, далайн худалдааны тухай зэрэг аж ахуйн 30 гаруй хууль орсон байна.²

Сүүлийн жилүүдэд амины болон хувийн аж ахуй эрчимтэй хөгжих болов. 1987 оны байдлаар 12 сая амины аж ахуйд 20 сая, 225 мянган хувийн аж ахуйд 3,6 сая хүн ажиллаж байв. Энэ нь нийгмийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зах зээлийг өргөжүүлэн, хүн амыг ажлаар болон хэрэгцээт бараа үйлчилгээгээр хангахад чухал үүрэг гүйцэтгэж, нийт социалист эдийн засагт үр ашигтай туслалцаа үзүүлж байгаа юм. Гэвч БНХАУ-ын Үндсэн хуульд хувийн өмчийн талаар ямар ч заалт байхгүй, аж ахуйгаа хөгжүүлэх хуульзүйн баталгаагүйн улмаас хувийн аж ахуйтнууд одоогийн бодлого өөрчлөгдөхөөс болгоомжлон, хөрөнгө мөнгө байвч үйлдвэрлэлээ өргөтгөлгүй, хүлээх аястай болжээ.

1. МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал УБ, 1988. 23 дахь тал
2. World Development Report, 1982. World Bank Wash 1982. p 112-113
3. UN, National Accounts Statistics Analysis of Main Aggregates, 1983/1984
4. UN Statistical Yearbook for Asia and the Far East Statistical Yearbook for Asia and pacific Bangkok. Various Editions, industrial Development Review Series, Thailand. Doc. UNIDO/is 5487. August 1985. p 15
5. UN Statistical Yearbook 1976, 1982. No 4. 1977, 1985
6. World Development Report 1980-1987
7. Lim. D. Economic Growth and Development in West Malaysia 1947-1970. Kuala Lumpur. 1973. p 258
8. Doc. UNlpo/s 548,7 August 1985. p 20
9. FAO production Yearbook 1973. p. 46-47. 1984. p 112-113. FAO Monthly Bulletin of Statistic 1986. vol 9 No 3 p 17
10. UN, Statistical Yearbook for Asia and the pacific 1984 Bangkok. 1986
11. ILO, Yearbook of Labour Statistics 1986. Geneva. 1986

Шинэтгэлийг гүнзгийрүүлэн, шинэчлэлтийн бүтээн байгуулалтыг түргэтгэх зорилгоор ХКН-ын Төв Хорооны саналын дагуу БХАТИХ-ын 7 дахь сонгуулийн анхдугаар чуулганаар (1988 оны 3, 4-р сар) Үндсэн хуульд хоёр өөрчлөлт оруулсаны нэг нь хувийн аж ахуйг хуульчлан бататгах асуудал байв. Үндсэн хуулийн 11-р зүйлд «Төрөөс хуулиар тогтоосон хэмжээнд хувийн аж ахуй оршин хөгжихийг зөвшөөрнө. Хувийн аж ахуй бол социалист нийгмийн аж ахуйн хавсарга мөн. Төрөөс хувийн аж ахуйн хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалж, түүнийг удирдан чиглүүлж, хяналт шалгалт тавина»³ гэсэн нэмэлт оруулав. Хоёр дахь өөрчлөлт ч өмчийн харилцааны асуудлыг хөндсөн бөгөөд нийгмийн өмчийн дотор гарч буй өөрчлөлтийг тусгасан юм. Урьд өмчлөх, эрхлэн хөтлөх эрхийг нэгтгэн ойлгож байсныг шинэтгэлийн явцад өөрчлөн 1984 оны III бүгд хурлаас «Өмчлөх эрх, аж ахуй эрхлэх эрхийг зааглах тухай» шинэ үндэслэл дэвшүүлэв. Хөдөө тосгонд хэдийнээ нэвтрүүлсэн эцсийн бүтээгдэхүүнийг олох орлоготой нь холбосон эрхийн гэрээт хариуцлагын систем бол хэрэг дээрээ газрыг өмчлөх, эзэмших эрхийг заагласан явдал юм. Газрыг бүх ард түмний өмч болгон коммуны мэдэлд өгснөөр түүнийг үнэ төлбөргүй, хугацаагүй ашиглах систем тогтож, мөн чанартаа хамтын мэдэлд орж, газарт үрэлгэн хүнийрхүү байдлаар хандаж байв. Энэ байдлыг өөрчлөхийн тулд гэрээт хариуцлагын систем нэвтрүүлэхийн зэрэгцээ газрыг үнэ төлбөртэй ашиглуулах туршилт явуулав. 1987 оноос Шанхай, Шэньжэн, Гуанжоу, Хайнаньдао зэрэг хот, мужид хийсэн туршилтын байдлаас харахад улсын газрыг үнэ төлбөртэйгээр ашиглуулах нь түүний ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд чухал түлхэц болж байна. Ийм ч учраас Үндсэн хуулийн 10-р зүйлийн 4-р хэсгийн «Ямар ч байгууллага, хүн газрыг эзэгнэх, зарах, худалдан авах, түрээс болон бусад хууль бус хэлбэрээр шилжүүлж болохгүй»⁴ гэсэн заалтыг «Ямар ч байгууллага, хүн газрыг эзэгнэх, зарах, худалдан авах болон бусад хууль бус хэлбэрээр шилжүүлэхийг үл зөвшөөрнө. Газар эзэмших эрхийг хуульд заасны дагуу шилжүүлж болно»⁵ хэмээн өөрчлөн найруулав.

Хөдөө тосгон дахь шинэтгэл гүнзгийрэх тутам шинэ нөхцөл байдал, шинэ асуудлууд бий болж байна. Өнөөг хүртэл тариачид аж ахуйгаа гэрээлэн эрхлэх талаар тусгай хууль дүрэм гараагүй, зөвхөн «Аж ахуйн гэрээний хууль» (1981), «Иргэний эрхийн ерөнхий анги» (1986), Ардын дээд шүүхээс гаргасан «Хөдөө дэх гэрээт хариуцлагатай холбогдсон маргаантай зарим асуудлын талаархи санал» (1986 оны 4-р сар) баримт бичгийг үндэс болгож байна. «Иргэний эрхийн ерөнхий анги»-ийн 28-р зүйлд «Хувиараа үйлдвэр, худалдаа эрхэлдэг өрх, аж ахуйгаа гэрээт хариуцлагын журмаар хөтөлдөг хөдөөгийн өрхийн хууль ёсны эрх ашгийг хуулиар хамгаална»⁶ гэж заажээ. Гэвч амьдрал дээр энэ заалт тэр бүр хэрэгжихгүй, янз бүрийн зөрчил маргаан үүсдгийн ихэнх нь хоршооллын байгууллага гэрээг дангаараа цуцалснаас болдог. Энэ нь зарим газрын удирдах хүмүүс тариачид хуулийн этгээд болж чадахгүй, аж ахуйн гэрээ (хариуцан дааж аж ахуй эрхэлдэг) энгийн гэрээнээс ялгаатай, хөдөөд хэрэглэх аргагүй хэмээн үздэгтэй холбоотой юм.

Мөн түүнчлэн гэрээ нь хоёр тал тохиролцон гарын үсэг зурснаас хойш хуулийн хүчинтэй болдгийг тэр бүр ойлгохгүй байх буюу олон жил дарга, гүйцэтгэгчийн байдлаар харьцаж сурсны дагуу тушаал гарган гэрээг өөрчлөх, хүчингүй болгох явдал ч байдаг. Ийм нөхцөлд дээд шүүхээс гаргасан баримт бичигт заасан ёсоор анхны гэрээг хүчин төгөлдөр байхыг хуулиар хамгаалж, учирсан хохирлыг гэрээлэгч хүнд нөхөн төлөх ёстой. Ер нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний болон

бордооны үнэ нэмэгдсэн зэрэг бүх хүчин зүйлийг сайтар бодолцон гэрээнд оролцогч хоёр этгээдийн эрх ашгийг адил тэгш харгалзан аливаа маргаан зөрчлийг шийдвэрлэнэ гэжээ⁷.

1984 онд хуралдсан ХКН-ын ТХ-ны III бүгд хурлаас гаргасан «Аж ахуйн системд шинэтгэл хийх тухай тогтоол»-д үйлдвэрийн газрын шинэтгэлийн мөн чанар нь өмчлөх, эрхлэх эрхийг зааглан салгаж, даргын хариуцлагын систем нэвтрүүлэх явдал гэдгийг тодорхойлон заасан. Тус бүгд хурлаас өмнө «Стандартчиллын дүрэм» (1979), «Социалист өрсөлдөөний тухай түр дүрэм» (1980), «Аж ахуйн гэрээний хууль» (1981), «Статистикийн хууль» (1983), «Улсын үйлдвэрийн газрын бие даасан байдлыг өргөжүүлэх тухай түр дүрэм» (1984) зэрэг хууль дүрмийг боловсруулан гаргасан байв. Гэхдээ аж ахуйн хууль тогтоомж гаргах явдлыг түргэвчлэн хот дахь шинэтгэлийн гол цөм болсон улсын үйлдвэрийн газрын шинэтгэлийн талаархи хуулийг даруйхан боловсруулах шаардлага тулгарч байлаа.

ХКН-ын ТХ, Төрийн зөвлөлөөс 1981—1984 онуудад ажилтан, ажилчдын төлөөлөгчдийн хурал, үйлдвэрийн даргын ажил, намын анхан шатны байгууллага, улсын үйлдвэрийн газрын тухай дүрмүүд боловсруулан мөрдүүлж байв. 1985 оны 1-р сард анх «Улсын үйлдвэрийн газрын хууль»-ийн төслийг БХАТИХ-ын БХ-оор хэлэлцүүлж, уг хуулийг цаашид боловсруулах комисс байгуулах шийдвэр гаргасан байна. Хуулийн төслийг нийт 4 удаа Байнгын хороогоор хэлэлцүүлж 10 гаруй удаа томоохон засвар оруулжээ. Төсөл хэлэлцэх явцад үйлдвэрийн даргын эрх, үүрэг, намын байгууллагын эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, хариуцлага зэрэг томоохон асуудлаар санал их зөрөлдөн, хурц маргаан өрнөж, зарим тохиолдолд 2 хувилбар боловсруулан хэлэлцэх тохиолдол ч гарч байлаа. 1987 оны X сард хуралдсан ХКН-ын XIII их хурал «шинэтгэлийг гүнзгийрүүлэх зорилт голчлон үйлдвэрийн газрын аж ахуйн механизмыг өөрчлөх асуудалд төвлөрч, төлөвлөлт, хөрөнгө оруулалт материаллаг нөөц, санхүү зээл, гадаад худалдааны зэрэг системүүдийг ээлж дараагаар өөрчлөн, улмаар социалист таваарын аж ахуйн шинэ системийн үндэс суурийг тавихад оршино»⁸ хэмээн тодорхойлоод, улсын үйлдвэрийн газарт даргын хариуцлагын систем хэрэгжүүлж, намын байгууллага хяналтын үүрэг гүйцэтгэнэ гэдгийг заажээ. Их хурлын энэхүү шийдвэр нь «Улсын үйлдвэрийн газрын хууль»-ийн үндсэн чиг шугамыг тодотгох, санал зөрөлдөөнийг шийдвэрлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлж, хуулийг боловсруулж батлах үйл явцад чухал түлхэц болсон юм. 1988 оны 1 сарын 12-нд хэвлэн нийтэлж бүх ард түмнээр хэлэлцүүлсний дараа мөн оны 3, 4-р сард хуралдсан БХАТИХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар «Улсын үйлдвэрийн газрын тухай БНХАУ-ын хууль»⁹-ийг батлав.

8 бүлэг 69 зүйлээс бүрдэх энэ хууль нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл дэх өмчлөгч, эрхлэн хөтлөгч, үйлдвэрлэгч (улс, үйлдвэр, хүн) гэсэн 3 үе шатны аж ахуйн 3 өөр харилцааг (улс ба үйлдвэр, үйлдвэр хооронд, үйлдвэрийн дотоод) хууль зүйн үүднээс зохицуулна.

Юуны өмнө улсын үйлдвэрийн газар бол орлогоороо зарлагаа нөхдөг, аж ахуйн бүрэн тооцоотой, бие даан үйлдвэрлэл явуулдаг социалист таваар үйлдвэрлэгч гэдгийг хуульчлан бататгаад, өмчлөх, эрхлэх эрхийг зааглан салгах үндсэн дээр аж ахуй хөтлөх эрхийг нэлээд өргөтгөв. (2-р зүйл)

Хуулийн 8-р зүйлд «ХКН-ын үйлдвэрийн газар дахь анхан шатны байгууллага нам, төрийн бодлого тухайн үйлдвэрийн газарт хэрэгжиж байгаад хяналт шалгалт тавина» хэмээн зааж урьд намын байгууллага дангаар удирддаг байсныг өөрчлөн түүнд зөвхөн улс

төрийн удирдлагыг үлдээн, материаллаг болон оюуны байгуулалтыг үйлдвэр өөрөө хариуцдаг болов.

1988 оны 8-р сарын 1-нээс энэ хууль үйлчилж эхлэхийн хамт үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбоотой бас нэг хууль хүчин төгөлдөр болов. Энэ бол 1986 оны 12-р сард БХАТИХ-ын БХ-ноос баталсан «Улсын үйлдвэрийн газар дампуурах тухай хууль» юм, 80-аад оны дунд үеэр БНХАУ-ын аж үйлдвэрт алдагдалтай ажилладаг үйлдвэр 20—30%-д хүрч тэдгээрийн ихэнх нь хоцрогдсон тоног төхөөрөмжтэй, ажиллагсдын мэргэжил боловсролын түвшин доогуур, бүтээгдэхүүний өөрийн өртөг асар өндөр байлаа. Нийт эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд улсаас хоцрогдсон үйлдвэрийн газрыг бөөцийлөн, элдэв хөнгөлөлт үзүүлдэгийг өөрчлөн, өртөг, өрсөлдөөн зэрэг таваар үйлдвэрлэлийн хуулиудын үйлчлэлийг өргөжүүлэх зорилгоор уг хуулийг гаргав. Энэ хуулийг гарахаас өмнө болон дараа нь Шэньянд хийсэн туршилтаас үзэхэд үйлдвэрийн өр үндсэн хөрөнгөнөөс давах буюу хэвийн нөхцөлд алдагдал нь 2 жил дараалан үндсэн хөрөнгийн 80 %-д хүрч байвал дампуурлын байдалд ордог. Хэрэв жилийн хугацаанд бүх талын тусламж үзүүлээд амжилт олохгүй бол үйлдвэрийг бүрэн хаана. Ажилчин, ажилтнуудад хагас жил цалингийн 75%-ийг олгож, цаашид ажил олдохгүй бол сард 30 юань даатгалын тусгай фондоос 2 жил өгдөг байна.¹⁰

Хятадын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70 гаруй хувийг гаргаж, эдийн засгийн ноён нуруу болсон улсын 9 түмэн үйлдвэрийн¹¹ үйл ажиллагааг зохицуулах хоёр гол хууль хэрэгжиж эхэлсэн нь шинэтгэлийн бодлогын үр дүн, аж ахуйн хууль тогтоомж дахь томоохон үйл явдал болсон бөгөөд шинэтгэлийг гүнзгийрүүлэн түргэтгэхэд өргөн бололцоо нээж өгөв.

Тус оронд хууль тогтоомжийн талаар «эхлээд ерөнхий тойм, дараа нь нарийвчлан тодруулах» гэсэн зарчим баримталж зарим хууль, дүрмийг түр хугацаагаар буюу туршилтын журмаар хэрэглэх явдал их өргөн дэлгэрч байна. Энэ байдлыг эдийн засгийн гадаад харилцааг зохицуулах хууль тогтоомжоос тодорхой харж болно.

1982 онд баталсан БНХАУ-ын Үндсэн хуулинд (18-р зүйл) гадаадын үйлдвэр, худалдааны байгууллага, иргэд тус улсын хуулийн дагуу хөрөнгө оруулах, эдийн засгийн хамтын ажиллагааг янз бүрийн хэлбэрээр явуулж болохыг тусгайлан зааж, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг төрийн хамгаалалтад авчээ.

1979 оны 7-р сард БХАТИХ-ын ээлжит чуулганаар баталсан «Хятадын болон гадаадын хөрөнгөөр байгуулсан хамтын үйлдвэрийн хууль»¹² бол нээлттэй бодлогыг хуульчлан бататгасан анхны алхам байлаа. Ердөө 15 зүйлээс бүрдэх энэ хуулинд Хятадын үйлдвэр, эдийн засгийн бусад байгууллагууд гадаадын үйлдвэр-худалдааны байгууллага, иргэдтэй хөрөнгө нийлүүлэн хамтын үйлдвэр байгуулах, ажиллуулах гол зарчмуудыг ерөнхий байдлаар заасан юм. Энэ хуулинд гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх хөнгөлөлтийг хятадад хөрөнгө ихээр татан оруулахтай нягт уялдуулахыг хичээсэн байна. Гадаадын түнш татвар төлсний дараа бүх орлогоо болон үйлдвэр зогсох үед эд хөрөнгөө авч явах эрхтэй бөгөөд орлогоосоо хятадад дахин хөрөнгө оруулбал татварыг багасгахаар заажээ. Үүнээс гадна хамтын үйлдвэрт бүтээгдэхүүнээ дотоод, гадаад зах зээлд гаргах, салбараа хилийн чанадад байгуулж, шаардлагатай техник, түүхий эд гаднаас авахыг зөвшөөрсөн байна.

Эдийн засгийн гадаад харилцаа өргөжсөнтэй холбогдуулан гааль татварын боловсронгуй систем бий болгох шаардлагын дагуу 1980 оны 9-р сард БХАТИХ-ын ээлжит чуулганаар «Хамтын үйлдвэрээс

ашиг орлогын татвар хураах тухай», «Хувь хүнээс ашиг орлогын татвар хураах тухай» хуулиудыг батлан гаргав.¹³ Хамтын үйлдвэрийн цэвэр ашгаас 33% (3% -орон нутгийн татвар)-ийн татвар хурааж буй нь Гонконгоос нэлээд өндөр боловч өрнөдийн орнуудынхаас бага юм. Гадаадаас хөрөнгийг урт хугацаагаар оруулахыг хөхүүлэн дэмжиж 10-аас дээш жил ажиллах үйлдвэрээс эхний жил бүрэн 2,3 дахь жил ашгийн татварын тэн хагасыг авахгүй. Мөн түүнчлэн орлогоосоо 5-аас дээш жилийн хугацаагаар дахин хөрөнгө оруулах тохиолдолд ашгийн татварын 40% -ийг буцаана. Гадаадад орлогоо авч гарахад оногдуулах татварыг бусад орнуудынхаас ихээхэн доогуур тогтоожээ.

«Хувь хүнээс ашиг орлогын татвар хураах тухай хууль» гол төлөв БНХАУ-д хөрөнгө оруулсан буюу худалдаа эрхэлж сард 800-аас дээш юаний орлого олдог гадаадынхан болон цагаач иргэдэд хамаарна. Ашиг орлогын татварыг 5—45% хүртэл өсгөн нэмэгдүүлэх, тогтмол 20 % -иар гэсэн 2 хэлбэрээр хураана.

Хэдийгээр хууль эрхийн ерөнхий үндэслэлийг нь боловсруулаагүй боловч ашиг орлогын асуудлыг хуульчлан заах нь чухал гэж үзэн «Гадаадын хөрөнгөөр байгуулсан үйлдвэрийн газраас ашиг орлогын татвар хураах тухай хууль»-ийг¹⁴ 1981 оны 12-р сард батлан гаргав. Уг хуулиар бас нэлээд хөнгөлөлт үзүүлэхээр заасны дотор орон нутгийн засаг захиргаанд үйлдвэр хэмжээгээр бага буюу орлого нь өндөр бус бол орон нутгийн татварыг авахгүй байх эрх олгожээ. Харин «Гадаадын хөрөнгөөр байгуулсан үйлдвэрийн газрын хууль»¹⁵-ийг хожим 1986 оны 4-р сард БХАТИХ-ын ээлжит чуулганаар баталсан юм. 1985 оны 3-р сарын 7-нд БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс «Гаалийн татварын дүрэм» гаргаж гаалийн татвар хураах журам, түүнийг хөнгөтгөх, чөлөөлөх нөхцөлийг тодорхойлон заав. 1987 оны 1-р сарын 13-нд «Гаалийн хууль»-ийг нээлттэй бодлогын өнөөгийн эрэлт шаардлаганд нийцүүлэн шинэчлэн баталлаа.

Гуандун мужийн Ардын төлөөлөгчдийн хурлаас (АТХ) гаргаж, 1980 оны 8-р сард БХАТИХ-ын БХ баталсан «Гуандун муж дахь онцгой бүсийн дүрэм»¹⁶ энэ талын асуудлыг зохицуулах хууль эрхийн гол акт болж байна. 6 бүлэг 26 зүйлтэй уг дүрмэнд мужийн нутаг дэвсгэр дээр үйлдвэр худалдааны үйл ажиллагааг нь эрхийн тусгай хэм хэмжээгээр зохицуулж, засаг захиргааны зохих байгууллагын ханалтанд байдаг онцгой бүсийг байгуулж болно гэж заажээ. Дүрэмд заасны дагуу онцгой бүсүүдийг удирдах тусгай хороо байгуулж, мужийн Ардын төлөөлөгчдийн хурлын нэрийн өмнөөс гадаадын хөрөнгө оруулах төслийг хянаж, батлах, онцгой бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө зохион хэрэгжүүлэх, хууль ёсыг сахин мөрдүүлэх зэрэг нийгэм-аж ахуйн бүхий л асуудлыг бүрэн хариуцна. Онцгой бүсэд гадаадынхан хөрөнгө ихээр оруулах өргөн бололцоо нээх зорилгоор тал бүрийн хөнгөлөлт үзүүлэх ажээ. Жишээ нь: ашиг орлогын татварыг 2 дахин бага буюу 15%-иар тогтоож, шаардлагатай техник, түүхий эдийг импортоор авахад гаалийн татвараас чөлөөлөх гэх мэт. Гэхдээ энд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зөвхөн гадаадад гаргах бөгөөд дотоод зах зээлд борлуулахын тулд тусгай зөвшөөрөл авч, гаалийн татвар төлөх ёстой.

1981 оны 11-р сарын 17-нд Гуандун мужийн АТХ-аас онцгой бүсэд орох, гарах: хөдөлмөр, цалингийн систем; аж ахуйн үйл ажиллагааг бүртгэх; газар эзэмших (энэ нь зөвхөн Шэньжэньд хамаарна)-тэй холбогдол бүхий 4 түр дүрэм баталж онцгой бүсийн дэглэм журмыг улам тодруулав. Үүнээс хэдхэн хоногийн дараа 11-р сарын 26-нд БХАТИХ-ын БХ «Гуандун, Фузян мужийн АТХ, түүний байнгын хороонд харьяандаа буй онцгой бүсүүдийн аж ахуйн бүхий л асуудлаар

тусгай дүрэм гаргах эрх олгох тухай» тогтоол гаргаж, онцгой бүсийн хууль хяналтын бүх асуудлыг орон нутгийн засаг захиргаанд бүрэн шилжүүлэв.

Хятадад гадаадын хөрөнгийг татан оруулах 3 дахь хэлбэр буюу хоршин үйлдвэр эрхлэхийг ихэд чухалчилж байна. Бүх зүйлийг хууль дүрмийн дагуу нарийвчлан тогтоохын тулд удтал хэлэлцээр хийх явдалгүй, богино хугацаагаар гэрээ байгуулан, аль алиныхаа давуу талыг ашиглан үйлдвэрлэл явуулах энэ хэлбэр энгийн, уян хатан байдлаар давуутай юм. Одоо гол төлөв ийм замаар гадаадын хөрөнгийг татан оруулж байгаа бөгөөд 1987 оны эцэст БНХАУ-д хоршсон 5193 үйлдвэр ажиллаж байлаа.¹⁷ Эдгээр үйлдвэрүүд «Хамтын үйлдвэрийн газрын хууль» (1979) «Гадаадтай аж ахуйн гэрээ байгуулах тухай хууль» (1985) болон бусад түр дүрмийг түшиглэн үйл ажиллагаагаа явуулж байлаа. Иймээс өсөн нэмэгдэж буй эрэлт шаардлагын дагуу 1988 оны 4-р сарын 13-нд БХАТИХ-ын ээлжит чуулганаар «Хятад гадаадтай хоршин эрхлэх үйлдвэрийн газрын хууль»¹⁸ баталж гаргав. Яагаад энэ чухал хуулийг ийм хожуу гаргах болсон бэ? Юуны өмнө онолын ч, практикийн байгууллагууд ч хоршсон, хамтарсан үйлдвэрүүд ямар ялгаатай, тус тусад нь хууль гаргах эсэх талаар санал их зөрж байгаад сүүлийн жилүүд үзэл бодол нэлээд ойртож, зарим ялгаа заагийг тодруулсан байна.

Үйлдвэрлэл зохион явуулах зарчмын хувьд хамтын хөрөнгөөр байгуулсан үйлдвэрт хувь нийлүүлэх, орлого хуваах харьцаа, өр алдагдлын талаар ерөнхийдөө нэгдмэл байдаг. Харин хоршсон үйлдвэрт эд бүхнийг хоёр тал хамтран ажиллах тухай гэрээ байгуулахдаа тохиролцдог. Хамтын үйлдвэрт гадаадынхны хөрөнгө оруулах хэмжээ 25%-иас доошгүй байх ёстой байдаг бол хоршсон үйлдвэрт тодорхой заалт байх шаардлагагүй. Орлого хуваах хэлбэрийн хувьд ч ялгаа бий. Хамтын үйлдвэр татвараа өгөөд үлдсэн орлогоо хуваадаг байхад, хоршсон үйлдвэрийн зарим нь ийм байдалтай, зарим нь татвараас өмнө бүтээгдэхүүн, орлогоо хуваан авдаг. 28 зүйлээс бүрдэх хоршин эрхлэх үйлдвэрийн газрын хууль хятадын хууль тогтоогчдын үзэж байгаагаар харьцангуй иж бүрэн, нарийн чанд боловсруулсан, улс орны бодит байдалд илүү нийцсэн хууль болжээ.

Аж ахуйн шинэ хуучин систем солигдож буй нарийн төвөгтэй өнөөгийн нөхцөлд нийгмийн харилцаанд гарч буй өөрчлөлтийг цаг тухайд нь хуульчлан бататгаж, элдэв эсэргүүцэл, сөрөг үзэгдлийн эсрэг тэмцэх, зарим тохиолдолд төөрөгдөл гажуудлаас сэрэмжлэхэд хууль тогтоомжийн үүрэг, ач холбогдол өссөөр байна. Одоо Хятад оронд энэ чиг хандлагатай уялдан, ялангуяа салбар, орон нутагт хууль, дүрмийн хүчээр шинэтгэл хийх мэт холбогдох хууль тогтоомж боловсруулан гаргахын төлөө хошууран хөөцөлдөх явдал байна.¹⁹ Иймд шинэтгэлийн одоогийн бодит байдал, хөгжлийн чиг хандлагыг сайтар судлан тулгамдсан чухал хууль тогтоомжийг боловсруулан гаргах цаг хугацааг зөв сонгохын зэрэгцээ, байгаа хууль, дүрэм, тогтоолоо нарийн чанд сахих явдал чухал зорилт болж байна.

1. Ляован, 1988, № 2, х. 5—6
2. Мөн тэнд, 1989, №13, х. 10—11
3. Гуанмин жибао, 1988, IV, 13
4. Конституция КНР, Бэйцзин. 1983 г. с. 19
5. Гуанмин жибао. 1988. IV, 13
6. Гуо у юань гунбао. 1986, №12, с. 371—392
7. Үз: Жэньминь жибао. 1988. IX, 21